



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

619.	Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2315
620.	Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2315
621.	Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	2316
622.	Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	2316
623.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	2317
624.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай	2317
625.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2317
626.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2318
627.	Концессийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2318
628.	Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2320
629.	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2321



630.	Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		2322
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ</b>			
631.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 48	2324
632.	Монгол Улсын 2011 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай	Дугаар 49	2324
633.	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Дугаар 50	2325
634.	Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2013 онд хүртгээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай	Дугаар 51	2326
635.	Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай	Дугаар 52	2327
<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b>			
636.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 190	2328
637.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 191	2328
638.	Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай	Дугаар 192	2329
639.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 194	2329
<b>МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>			
640.	Журам батлах тухай	Дугаар 97	2330



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4 дэх заалтын “болон концессын гэрээгээр хэрэгжүүлэх” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.4.7 дахь заалт, 32 дугаар зүйлийн 32.2.19 дэх заалт, 33 дугаар зүйлийн 33.2.7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажил олгогчийн болон даатгуулагчийн төлөх тэтгэмжийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5” гэснийг тус бүр “0.8” гэж, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ “0.5” гэснийг тус бүр “0.2” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУВЬ ХҮНИЙ ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/16 дугаар зүйлийн 16.1.16 дахь заалт:**

“16.1.16. мөнгөн хадгаламжийн нийт хэмжээ нь 100 сая төгрөгөөс дээш нэг жил ба түүнээс бага хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн хүүгийн орлогоос бусад Монгол Улсын иргэний мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд.”

#### **2/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:**

“19.3. Албан татвар ногдуулах мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогыг тодорхойлохдоо албан татвар төлөгчийн тухайн банкин дахь нийт хадгаламжийн хүүгийн орлогоос энэ хуулийн 16.1.16-д заасан чөлөөлөгдөх хадгаламжийн хүүгийн орлогыг хасч тооцно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.8 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

З.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр баталсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “2012 оны” гэснийг “2013 оны” гэж өөрчилсүгэй.



**2 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС  
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “2012 оны” гэснийг “2013 оны” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

**КОНЦЕССЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Концессын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/6 дугаар зүйлийн 6.2.4-6.2.6 дахь заалт:**

“6.2.4.төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын талаарх саналыг бэлтгэж Засгийн газарт оруулах;

6.2.5.концессын зүйлийн талаар судалгаа хийх, санал боловсруулах;

6.2.6.концессын зүйлийн жагсаалтыг нийтэд мэдээлэх;”

**2/9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь хэсэг:**

“9.4.Төрийн өмчийн концессын зүйлийн хувьд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 10.1-д заасан



жагсаалтад оруулах концессын зүйлийн талаарх энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан саналаа зардал, ашгийн тооцооны хамт эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

9.5.Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тусган концессын зүйлийн жагсаалтын талаарх саналаа эцэслэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Концессын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсгийн “эд хөрөнгийг” гэсний дараа “концессын гэрээнд өөрөөр заагаагүй бол” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Концессын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.2.Төрийн өмчийн концессын зүйлийн хувьд энэ хуулийн 18.1-д заасан саналд төсвийн дэмжлэг шаардлагатай бол санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авсан байна.”

**4 дүгээр зүйл.**Концессын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “Улсын Их Хурал” гэснийг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Улсын Их Хурал тухайн жилийн төсвийн тухай хуульд тусган” гэснийг тус тус “Засгийн газар” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг” гэснийг “эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “жагсаалтын төслийг Төсвийн тухай хуулийн 32.1-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэснийг “жагсаалтыг батлах” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын” гэснийг “эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын” гэж, 9.6 дахь хэсгийн “санхүү, төсвийн” гэснийг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “тухайн” гэснийг “эдийн засгийн хөгжлийн” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалтын “төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 6 дугаар зүйлийн 6.2.4-6.2.10 дахь заалтын дугаарыг “6.2.7-6.2.13” гэж, 9 дүгээр зүйлийн 9.4-9.6 дахь хэсгийн дугаарыг “9.6-9.8” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөнө.



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, заалт нэмсүгэй:

#### 1/11<sup>1</sup> дүгээр зүйл:

#### “11<sup>1</sup> дүгээр зүйл.Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

11<sup>1.1</sup>.Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11<sup>1.1.1</sup>.хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны нөхцөлийг тогтоох, уг үнэт цаасны төлбөрийн хуваарийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн шийдвэрлэх;

11<sup>1.1.2</sup>.зээл, тусламжийн нэгдсэн бодлого, зохицуулалтын удирдлагыг хэрэгжүүлэх.”

#### 2/13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт:

“13.1.3.хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны болон зээлийн нөхцөлийг өөрчлөх санал боловсруулах, уг үнэт цаасны төлбөрийн хуваарийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн шийдвэрлэх.”

**2 дугаар зүйл.**Төсвийн тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### 1/11 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалт:

“11.1.8.зээл, тусламжийн санхүүжилт, үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх;”

#### 2/11 дүгээр зүйлийн 11.1.14 дэх заалт:

“11.1.14.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны нөхцөлийг тогтоох, тухайн жилийн төсвийн болон төсвийн нэмэлт, өөрчлөлттэй нь хамт батлуулах;”





**3/12 дугаар зүйлийн 12.1.10 дахь заалт:**

“12.1.10.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны нөхцөлийг өөрчлөх, зээл төлөх санал боловсруулах;”

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА,  
САНХҮҮЖИЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 8<sup>1</sup> дүгээр зүйл нэмсүгэй:

**“8<sup>1</sup> дүгээр зүйл.Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн  
Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

8<sup>1</sup>.1.Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8<sup>1</sup>.1.1.хөрөнгө оруулалтын зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны болон зээлийн нөхцөлийг өөрчлөх, төлбөрийн хуваарийг Төсвийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн шийдвэрлэх.”

**2 дугаар зүйл.**Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8, 8.1.9 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.1.8.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны нөхцөлийг тогтоох, тухайн жилийн төсвийн болон төсвийн нэмэлт өөрчлөлттэй нь хамт батлуулах;

8.1.9.зээл, тусламжийн санхүүжилт, үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх, Засгийн газрын шийдвэрээр зээлийн баталгаа гаргах;”



**3 дугаар зүйл.** Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2012 оны 10 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдөр баталсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд дор дурдсан агуулгатай 6 дугаар зүйл нэмсүгэй:

**“6 дугаар зүйл.** Энэ хуулийн 1 дүгээр зүйлийн 15 дахь заалтын “43.5.Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 3.1.15-д заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 12 сарын, сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 18 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас олгох бөгөөд шаардагдах зардлыг нь тухайн жилийн төсөвт тусгана.” гэснийг, 3 дугаар зүйлийн 4 дэх заалтын “43.1.7.а.сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч / сургалтын менежер/, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, сургууль, цэцэрлэгийн эмч;” гэснийг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.”

**2 дугаар зүйл.** 2012 оны 5 дугаар сарын 09-ний өдөр баталсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн дараах заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/1 дүгээр зүйлийн 15 дахь заалт:**



**“15/43 дугаар зүйлийн 43.4, 43.5 дахь хэсэг:**

“43.4.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, бусад албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгох бөгөөд уг урамшууллын хэмжээ, түүнийг олгох журмыг Төрийн албаны тухай хуулийн 31.3-т заасны дагуу Засгийн газар батална.

43.5.Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 3.1.15-д заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 12 сарын, сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан бол өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 18 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас олгох бөгөөд шаардагдах зардлыг нь тухайн жилийн төсөвт тусгана.”

**2/3 дугаар зүйлийн 3, 4 дэх заалт:**

**“3/43 дугаар зүйлийн 43.1.4 дэх заалт:**

“43.1.4.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн сургалт- үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт энэ хуулийн 43.1.2-т заасан албан тушаалд 25 ба түүнээс дээш жил ажилласан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгоход 24 сарын, үүнээс сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгт 10 ба түүнээс дээш жил ажилласан бол 36 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг төрийн албан хаагчийн цалингийн сүлжээг баримтлан улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох;”

**4/43 дугаар зүйлийн 43.1.7 дахь заалт:**

“43.1.7.Дараах этгээдэд 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг улсын төсвөөс ажиллаж байгаа байгууллагаар нь дамжуулан олгох:

43.1.7.а.сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, сургууль, цэцэрлэгийн эмч;

43.1.7.б.сум, тосгон, багийн сургууль, цэцэрлэгийн энэ хуулийн 43.1.7.а-д зааснаас бусад багш, туслах багш.”



**3 дугаар зүйл.**2012 оны 5 дугаар сарын 09-ний өдөр баталсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн дугаарыг “7” гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 10 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 48

Улаанбаатар  
хот

**Хуулийн төсөл буцаах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2012 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 10 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 49

Улаанбаатар  
хот

**Монгол Улсын 2011 оны төсвийн  
гүйцэтгэлийг батлах тухай**

Төсвийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын 2011 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогыг 3.351.389.0 сая /гурван их наяд гурван зуун тавин нэгэн тэрбум



гурван зуун наян есөн сая/ төгрөгөөр, зарлагыг 3.621.676.2 сая /гурван их наяд зургаан зуун хорин нэгэн тэрбум зургаан зуун далан зургаан сая хоёр зуун мянган/ төгрөгөөр тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 10 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 50

Улаанбаатар  
хот

**Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

**Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга:**

-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд

**Засгийн газрыг төлөөлсөн гишүүнээр:**

- 1/Сангийн сайд;
- 2/Хууль зүйн сайд;
- 3/Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд

**Даатгуулагчийг төлөөлсөн гишүүнээр:**

- |                                |   |
|--------------------------------|---|
| 4/Хаянхярваагийн Амгаланбаатар | -Монголын<br>үйлдвэрчний<br>эвлэлийн холбооны<br>дэд ерөнхийлөгч                        |
| 5/Дагвадоржийн Дулмаа          | -Монголын чөлөөт<br>үйлдвэрчний<br>эвлэлүүдийн нэгдсэн<br>холбооны тэргүүлэгч<br>гишүүн |



6/Цэндсүрэнгийн Отгонбаяр

-Монголын татвар төлөгчдийн үйлдвэрчний эвлэлийн үндэсний холбооны удирдах зөвлөлийн гишүүн

**Ажил олгогчийг төлөөлсөн гишүүнээр:**

7/Хуягийн Ганбаатар

-Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны дэд ерөнхийлөгч

8/Домбонгийн Үүрийнтуяа

-Монголын албан бус эдийн засгийн нэгдсэн холбооны удирдах зөвлөлийн гишүүн

9/Жанчивдоржийн Батбаяр

-“Кассандра Монголиа” ХХК-ийн ерөнхий захирал.

2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 2006 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 55 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 10 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 51

Улаанбаатар хот

**Хүний хөгжил сангаас Монгол Улсын иргэнд 2013 онд хүртээх хишиг, хувийн хэмжээг тогтоох тухай**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүн ам, өрхийн шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэнд 2013 онд Хүний хөгжил сангаас хүртээх хишиг, хувийн хэмжээг дор дурдсанаар тогтоосугай:



1/0-18 хүртэлх насны хүүхэд бүрд сар бүр 20 000 /хорин мянга/ төгрөг

2.Энэ тогтоолыг 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2012 оны 10 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 52

Улаанбаатар  
хот

### **Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эдийн засгийн өсөлтийг хангах, урт хугацааны хөгжлийн хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжих бодлогыг санхүүжүүлэх зорилгоор дунд, урт хугацааны 5 тэрбум /таван тэрбум/ хүртэлх ам.долларын Засгийн газрын үнэт цаасыг 2012-2014 онуудад үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т зөвшөөрсүгэй.

2.Энэхүү хөрөнгийг нийгмийн халамжийн аливаа үйлчилгээ болон улсын төсвийн орлогын дутагдлыг нөхөхөөс бусад эрдэс баялаг, зам, тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, барилга, банк санхүү, аж үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх эдийн засгийн үр ашиг бүхий томоохон төслүүдэд хөрөнгө оруулахад зарцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтийн явцын талаар жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /Н.Алтанхуяг/-т, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Б.Гарамгайбаатар/-нд тус тус үүрэг болгосугай.

4.Энэ тогтоолыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**3.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 10 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 190

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Шинэ Зеланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цэрэндоржийн Жамбалдоржийг эгүүлэн татаж, Шинэ Зеланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Равдангийн Болдыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц. ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 10 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 191

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ворошиловын Энхболдыг эгүүлэн татаж, Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Санжаасүрэнгийн Баярааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц. ЭЛБЭГДОРЖ**





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 10 дугаар  
сарын 23-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар  
хот

### Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 20 дугаар зүйлийн 20.2, Улсын Их Хурлын 2006 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн даргын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журмын 2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Сонгуулийн ерөнхий хорооны дарга Чойнзонгийн Содномцэрэнд тэргүүн түшээ, нарийн бичгийн дарга Батнямын Алтанжаргалд дэд түшээ зэрэг дэвийг тус тус олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц. ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 10 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 194

Улаанбаатар  
хот

### Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Индонез Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лувсандоогийн Дашпүрэвийг эгүүлэн татаж, Бүгд Найрамдах Индонез Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чимиддоржийн Баттөмөрийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц. ЭЛБЭГДОРЖ**



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 10 дугаар  
сарын 20-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар  
хот

### Журам батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 9.2.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн буюу консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг бүртгэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны сайд Л.Болдод даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**

**Л.БОЛД**

Засгийн газрын 2012 оны 97 дугаар  
тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСАД СУУГАА ГАДААД УЛСЫН ДИПЛОМАТ  
ТӨЛӨӨЛӨГЧИЙН БУЮУ КОНСУЛЫН ГАЗАР, НҮБ, ТҮҮНИЙ  
ТӨРӨЛЖСӨН БАЙГУУЛЛАГЫН СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН  
ГАЗАР, ГАДААД УЛС, ОЛОН УЛСЫН ХЭВЛЭЛ  
МЭДЭЭЛЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАРТ  
АЖИЛЛАХ ГАДААДЫН ИРГЭНИЙГ  
БҮРТГЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 32.1-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг (цаашид “гадаадын иргэн” гэх) бүртгэх, бүртгэлээс хасах, Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгох, хугацааг нь сунгах, өөрчлөх, хүчингүй болгох үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.



1.2. Энэ журмыг хэрэгжүүлэхдээ Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенц, Консулын харилцааны тухай 1963 оны Венийн конвенц, Засгийн газрын 2010 оны 340 дүгээр тогтоолоор баталсан Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам, бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

1.3. Энэхүү журмыг хэрэгжүүлэхдээ тухайн гадаад улстай хэрэгжүүлж байгаа хоёр талын харилцаан дахь харилцан адил байх зарчмыг баримтална.

1.4. Засгийн газрын 2010 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”-ын 13.6.1 болон энэ журмын 2.1-д заасан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнд Монгол Улсад оршин суух А-1 үнэмлэх олгоно.

1.5. Гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудын суурин төлөөлөгчийн газар (цаашид “төлөөлөгчийн газар” гэх)-т ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг бүртгэх, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгох үйл ажиллагааг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дипломат ёслолын асуудал эрхэлсэн нэгж гүйцэтгэнэ.

1.6. Гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газар (цаашид “төлөөлөгчийн газар” гэх)-т ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг бүртгэх, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгох үйл ажиллагааг гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээлэл, гадаад сурталчилгааны асуудал эрхэлсэн нэгж гүйцэтгэнэ.

#### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэ журам нь дор дурдсан гадаадын иргэн болон тэдгээрийн гэр бүлийн гишүүнд үйлчилнэ:

а. Элчин сайд, түр хамаарагч;

б. Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын суурин төлөөлөгч;



- в. Элчин сайдын яамны дипломат ажилтан;
- г. Консул;
- д. Консулын газрын ажилтан;
- е. Элчин сайдын яамны захиргаа-техникийн болон үйлчилгээний ажилтан;
- ё. Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын ажилтан;
- ж. Гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгч;
- з. Хувийн үйлчилгээний ажилтан;

2.2. Гэр бүлийн гишүүнд албан ёсоор гэрлэсэн эхнэр буюу нөхөр, 24 хүртэлх насны, гэрлээгүй, эцэг эхтэйгээ хамт амьдардаг, төрүүлсэн болон албан ёсоор үрчилж авсан хүүхэд, өөрийн эцэг, эх болон эхнэрийн (нөхрийн) эцэг, эх хамаарна.

#### Гурав. Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олгох

3.1. Энэ журмын 2.1-д заасан гадаадын иргэнийг томилогч улс, НҮБ, түүний төрөлжсөн байгууллага болон хэвлэл мэдээллийн төлөөлөгчийн газрын гишүүдийг томилсон ноот, хүсэлтийг урьдчилан хүлээн авсан тохиолдолд зохих ангиллын визийн зөвшөөрлийг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тухайн гадаад улсад суугаа Монгол Улсын Элчин сайдын яаманд хүргүүлнэ.

3.2. Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар энэ журмын 3.1-д дурдсан визийг олгохдоо тухайн улсын гадаад хэргийн яам, олон улсын болон хэвлэл мэдээллийн байгууллагын ноот бичиг, албан захидлыг үндэслэн олгоно.

3.3. Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх авсан энэхүү журамд хамаарах гадаадын иргэнд Монгол Улсад зорчих олон удаагийн визийг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгж олгоно. Олон удаагийн визийн хүчинтэй байх хугацаа нь оршин суух зөвшөөрлийн хугацаагаар тодорхойлогдоно.

#### Дөрөв. Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгох

4.1. Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэнийг ажлын 10 хоногт багтаан бүртгэж, Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгоно.



4.2. Төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн нь анх хүрэлцэн ирээд энэ тухайгаа төлөөлөгчийн газрынхаа ноот, албан бичгээр гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэнэ.

4.3. Төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн нь Монгол Улсад ирсэн өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлж, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх хүснэ.

4.4. Төлөөлөгчийн газар нь орон тоо нэмэгдэж байгаа тухайгаа гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

4.5. Төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэн бүртгүүлж, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх хүсэхдээ дараахь бичиг баримтыг бүрдүүлж, гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад өгнө:

- Ноот, албан захидал зэрэг бичиг баримт
- Паспортын эх хувь
- Гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл хүссэн анкет
- 3 см х 4 см хэмжээтэй шаардлага хангасан хоёр хувь фото зураг.

4.6. Дипломат болон консулын ажилтан нь гадаад улсын иргэнийг хувийн үйлчлэгчээр ажиллуулах тохиолдолд түүнийг бүртгүүлж, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх хүсэхдээ энэхүү журмын 4.5-д заасан баримт, бичгээс гадна түүнийг бүрэн хариуцах тухай батламж гаргана. Батламжийг төлөөлөгчийн газрын тэргүүн баталгаажуулна.

4.7. Төлөөлөгчийн газарт ажиллах гадаад улсын иргэнд дараахь төрлийн үнэмлэх олгоно:

4.7.1. Дипломат үнэмлэх. Дипломат үнэмлэхийг дор дурдсан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнд олгоно:

- а. Элчин сайд, түр хамаарагч;
- б. Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын суурин төлөөлөгч;
- в. Элчин сайдын яамны дипломат ажилтан.



4.7.2. Албан үнэмлэх. Албан үнэмлэхийг дор дурдсан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнд олгоно:

- а. Консул;
- б. Консулын газрын ажилтан;
- в. Элчин сайдын яамны захиргаа-техникийн болон үйлчилгээний ажилтан;
- г. Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газрын ажилтан;
- д. Гадаад улс, олон улсын хэвлэл мэдээллийн төлөөлөгч;
- е. Хувийн үйлчилгээний ажилтан.

4.8. Төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэний гэр бүлийн гишүүн тус бүрт үнэмлэх олгох бөгөөд үнэмлэх нь ижил төрлийнх байна.

4.9. Төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа гадаадын иргэн хүүхэд төрүүлсэн, хууль ёсоор үрчилж авсан бол энэ тухайгаа гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэн түүнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, үнэмлэх авна.

4.10. Төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнд олгох Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, үнэмлэхийг хүсэлт тавьсан ноот, албан захидалд заасан хугацаагаар олгоно. Зөвшөөрөл, үнэмлэхийг анх удаа олгож байгаа бол түүний хүчинтэй хугацаа нь 3 хүртэл жил байна.

4.11. Төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүний оршин суух зөвшөөрлийг түүний паспорт дээр хийнэ. НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газарт ажиллах гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг НҮБ-ын лэссэ-пассе дээр тэмдэглэнэ.

4.12. Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, үнэмлэхийг монгол, англи хэл дээр үйлдэх бөгөөд гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжийн дарга гарын үсэг зурж баталгаажуулан тэмдэг дарна.

4.13. Энэ журамд заасан бүртгэл хийх, оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгоход ямар нэгэн төлбөр, хураамж авахгүй.



Тав. Зөвшөөрөл, үнэмлэхийн хүчинтэй байх хугацааг сунгах, дахин олгох, бүртгэлээс хасах, хүчингүй болгох

5.1. Төлөөлөгчийн газрын албан ёсны хүсэлтийг үндэслэн төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүний оршин суух зөвшөөрөл, үнэмлэхийн хүчинтэй байх хугацааг сунгана. Оршин суух зөвшөөрөл, үнэмлэхийн хүчинтэй байх хугацааг сунгуулах хүсэлтийг төлөөлөгчийн газар хугацаа дуусахаас нэг сарын өмнө гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тавина.

5.2. Төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа гадаадын иргэний албан тушаал өөрчлөгдсөн бол тухайн гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүний оршин суух үнэмлэхийг дахин олгоно.

5.3. Төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн шинэ паспорт авсан тохиолдолд оршин суух зөвшөөрлийг нь шинэ паспорт дээр шилжүүлэн тэмдэглэн өгч болно. Энэ тохиолдолд хуучин паспорт дээр байгаа өмнөх зөвшөөрлийг хүчингүй болгоно.

5.4. Зөвшөөрөл, үнэмлэхийг гээгдүүлсэн, үрэгдүүлсэн тохиолдолд төлөөлөгчийн газрын албан ёсны хүсэлт, цагдаагийн газрын тодорхойлолтыг үндэслэн зөвшөөрөл, үнэмлэхийг дахин олгоно.

5.5. Үнэмлэх дахин олгохдоо тухайн гадаадын иргэний оршин суух үнэмлэхийн дугаарыг өөрчлөхгүй.

5.6. Төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа гадаадын иргэн дор дурдсан тохиолдолд бүртгэлээс хасуулж, оршин суух зөвшөөрөл, үнэмлэхийг гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хураалгана:

-төлөөлөгчийн газарт ажиллаж байсан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн бүрмөсөн буцсан;

-төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүний Монгол Улсад оршин суух эрх зүйн байдал өөрчлөгдсөн;

-төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа гадаадын иргэний хүүхэд гэр бүл болсон, 24 нас хүрсэн бол.



5.7. Эрх бүхийн байгууллагаас хүсэлт гаргасан тохиолдолд гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага төлөөлөгчийн газарт ажиллаж байсан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнд Монгол Улсад оршин суух зөвшөөрөлтэй байсан тухай тодорхойлолт гаргаж өгч болно.

5.8. Төлөөлөгчийн газарт ажиллаж байсан гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүн бүртгэлээс хасуулж, оршин суух зөвшөөрөл, үнэмлэхээ гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад зохих ёсоор хураалгаагүй бол түүний оронд ажиллахаар ирэх гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг бүртгэж, Монгол Улсад оршин суух зөвшөөрөл, үнэмлэх олгохгүй.

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.  
Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)  
Утас: 262420, 329612  
Хэвлэлийн хуудас: 1.5  
Индекс: 14003